

“МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО”-Н ДЭХ ДРАМЫН ШИНЖТЭЙ ХЭСГҮҮД

С.Хөвсгөл, профессор, НХУС

Резюме: В данной статье рассматриваются проблемы изображения основных конфликтов главного литературного памятника монголов. Автор считает, что в “Сокровенном сказании Монголов” имеются элементы трагедии, комедии, а также драмы.

Элементы трагического есть в параграфах 76-78, где рассматриваются конфликт разногласия между родными братьями по отцу. Их мать Оулэн боится что это отразится в их дальнейшей жизни и государства. А также в параграфе 244 изображается конфликт между Чингис ханом и его братом Хасар.

Элементы комического рассматриваются в параграфах 194-195, где изображена борьба между Таян хан и Чингисовых войск. Таян хан сначала подумал, что легко одолеть монголов, так как они варвары. Но когда начались бои, он от преувеличенных слов Жамухи, боится и бежит от монголов к вершину горы.

В драматических по конфликту отрывках изображено отношение Чингис хана с Ван ханом в параграфах 166-167. Сначала они были союзниками. Их рассорит сын Ван хана-Сэнгүм, не без участия Жамухи. Здесь главное заключается в борьбе за власть.

В параграфах 200-201 изображён конец или разрешение конфликта между Чингис хана и Жамухи. Каждый феодал хотел стать главой монголов, но Жамуха был особенным полтивиком Чингис хана. Он смог предать союзников, когда считал выгодным. Его мысли иногда неумовимы.

Автор статьи делает выводы, что во всех памятниках древнемонгольской литературы имеются элементы драматического, в таких как “Диалог между сироты и 9-ю вассалами Чингис хана”, “Повесть о двух скакунах Чингис хана”. В некоторых случаях конфликт скрытен, но очень драматичный.

Түлхүүр үг: Монголын нууц товчоо, эмгэнэлт жүжиг, хошин жүжиг, драмын жүжгийн ай, зөрчил

Монголын уран зохиолын анхны бичмэл дурсгал “Монголын нууц товчоо” нь Орос зөвлөлтийн монголч эрдэмтэн, академич С.А.Козиний бичсэнээр “Түүхэн, баримтат, туульсын, уянгын, туужийн, тэрчлэн эмгэнэлт ба инээдмийн жүжгийн элементүүд зэрэг олон төрлийг багтаасан зохиол” (Козин, С. А. (1941) “Сокровенное сказание Монголов”. Москва-Ленинград. с.16) юм.

“Монголын нууц товчоо”-ны үйл явдал нь ерөнхийдөө маш товч цухас дүрслэгдсэн онцлогтой боловч зарим хэсгийг нь их тодорхой бичсэн байдаг. “Монголын нууц товчоо”-ны 282 зүйлийг үйл явдлаар нь бүлэглэвэл гуч шахам өгүүлэмж болох бөгөөд үүний арван тав орчим нь хурц үйл явдалтай, хүний сэтгэлийн дотоод зөрчил, хүмүүсийн хоорондын зөрчлийг дүрслэхдээ их драматизмтай харуулсан байдаг. Энэ нь нэг талаас дүрээ бүтээх зохиолчийн уран чадварыг харуулахын зэрэгцээ нөгөө талаас тухайн цаг үеийнхээ хурц ширүүн зөрчил тэмцлийг тусгасан хэрэг юм. Тэрчлэн монголын эртний уран зохиолын нэг онцлог нь драмын шинж болохыг “Чингисийн есөн өрлөгтэй өнчин хүүгийн цэцэлсэн шастир”, “Эр хоёр загалын

тууж” гэх мэт зохиолоос үзэж болох юм.

Алан гуа эхийн домог, Өэлүн үжинг Чилүдэгээс булааж авсан, Есүгэйг нас барсны дараа тайчууд Өэлүнг хүүхдүүдтэй нь хаяж нүүсэн, Найманы Таян хаантай байлдсан нь, Чингис Хасарыг байцаасан, Хонхотангуудыг номхруулсан зэргээс гадна Жамуха Ван хаантай зөрчилдсөн гэх мэт олон хэсгүүд нь гүнзгий зөрчил, хурц үйл явдалтай бөгөөд зөрчил нь түргэн хугацаанд шийдэгдэж, голлон асуулт хариултаар бичигдсэн, их санааг цөөн үгэнд хураангуйлж чадсан байдаг.

Энэ хэсгүүдээс зарим нь эмгэнэлтэй \Бэгтэрийг харваж алсан, Хасарыг байцаасан\, инээдэмтэй \Найманы Таян хаантай байлдсан\, драмын зөрчилтэй \Ван хаан Сэнгүмийн ятгалганд орж, Чингистэй байлдах болсон, Жамух Чингис хоёрын харьцаа\ зэрэг олон янзын өнгө аястай юм.

Нэг.

Зүйл 76,77,78-д Өэлүн эхийн хөвгүүд Есүхэйн нөгөө нэг хатан Сочигал эхийн хөвгүүд хоорондоо эвдрэлцэж, Тэмүжин Хасар хоёр Бэгтэрийг харван алсан нь Өэлүн эхийн хувьд тун эмгэнэлтэй үйл явдал болдог. Энд Өэлүн эх чухамхүү ирээдүйн эмгэнэлт явдлын үндсийг олж харсан ч байж болох юм. Тэмүжин багадаа Хасартай нийлж, Бэгтэрийг

алсан бол хожим нь Хасартайгаа эвдэрдэг. Ийнхүү нэгэн эцгийн, нэгэн эхийн хүүхдүүд хоорондоо эвдрэлцэх нь эх хүний хувьд хамгийн эмгэнэлтэй үйл явдал болох нь ойлгомжтой. Тэмүжин Хасар хоёр эхлээд Бэгтэр Бэлгүдэй хоёрыг ховлож ирэхэд, Өүлэн: “Та нар нэгэн эцгийн хөвгүүд байтал юунд тэгэж маргалдана? Одоо сүүдрээс өөр нөхөргүй, сүүлнээс өөр ташуургүй байгаагаа мэдэх биз. Ийм бол бид Тайчууд нараас яаж өшөөгөө авч чадна? Урьдын Алангуа эхийн таван хөвгүүд мэт яагаад эв эегүй болов? Та нар битгий тэг” (Ц.Дамдинсүрэнгийн хөрвүүлэг. (1976) “Монголын нууц товчоо” Улаанбаатар. Зүйл 76. Тал 38) гэсэнд хоёр хөвгүүн үгийг нь хэрэгсэлгүй ... гараад Бэгтэрийг харваж алчихчаад ирэхэд, эх “хоёр хөвгүүнийхээ царайг хармагц даруй учрыг мэдэж” гэсэн нь эхийн сэтгэлд юу болдог бол хэмээн хэрхэн зовниж, бас ч үгийг нь тоохгүй байж магадгүй гэж мэдэрч байсныг харуулдаг. Ийнхүү энэ үгсээр Өэлүн эхийн сэтгэлийн дотоод зөрчлийг тун хураангуй атлаа тодорхой дүрсэлжээ. Ингээд цааш нь Бэгтэрийг алсныг мэдмэгц бухимдан хилэгнэж, хоёр хүүгээ зүхэж буй нь мөн түүний сэтгэлийн хөдөлгөөнийг маш хүчтэй илэрхийлдэг. Энэ зүхэл шүлэгт зүйрлэлийн аргыг хэрэглэж, ах дүүгийнхээ амийг хөнөөсөн булай явдлыг үзэн ядаж, харгис догшноороо нэртэй адгуус амьтантай зүйрлэсэн, нэг үгээр хэлэхэд Өэлүн үжиний өчил яриа \монолог\ болсон юм.

Хавиргаа хазах хар нохой мэт

Хаданд довтлох харцага шонхор мэт

Уураа даран ядах омогт арслан мэт

Амьдыг залгих аюулт мангас мэт... гэх мэтээр шүлэглэжээ.

Харин шүлгийн эхэнд “Халуун хэвлээс гарахдаа хар нөж атган төрсөн билээ” гэсэн нь Тэмүжингийн гартаа нөж атган төрсөнд Өэлүн үжин анхнаасаа зэвүүцэн, муу зөн совин гэж үзэж байсныг харуулна. Тэрчлэн “сүүдрээс өөр нөхөргүй, сүүлнээс өөр ташуургүй” (Ц.Дамдинсүрэнгийн хөрвүүлэг. (1976) “Монголын нууц товчоо” Улаанбаатар. Зүйл 78. Тал 38-39) гэж Есүхэй баатрыг үхсэнээс хойш садан аймгууд цөм хаяж нүүснийг хэлжээ. Энэ мэтээр энэ гурван зүйлд маш олон чухал санааг хураангуйлан гаргасан юм. Энд 77-р зүйлд Бэгтэрийн дүр цухас гарах боловч уужим ухаантай, эрэлхэг хүн болж дүрслэгдсэн. Түүний хэлсэн үгэнд гүнзгий санаа илэрдэг.

Тэрчлэн Тэмүжиний хүүхэд байхдаа үйлдсэн энэ гэм нь хожим эцэг хүү бололцсон Ван хаантай дайсан болсон хийгээд, анд Жамухтай олон дахин дайсагнахыг урьдчилан зөгнөсөн ч байж болох юм. Мөн 244-р зүйлд Хонхотангуудын

ховлосноор Хасарыг барьж аваад байцаан асууж байхад Өэлүн үжин “Сүйх тэргэнд цагаан тэмээ хөллөөд мөн шөнө турш явж, наран ургах үеэр хүрч” (Ц.Дамдинсүрэнгийн хөрвүүлэг. (1976) “Монголын нууц товчоо” Улаанбаатар. Зүйл 244. Тал 200) ирж буй хэсэгт нь драмын шинж их тод илэрдэг. Хэрэв Өэлүн эх тэгэж ирж амжаагүй бол Хасарыг хөнөөчих байсан нь илэрхий. Өэлүн эх олон жилийн өмнө Бэгтэрийг алсны адил ах дүүгийн алалдаан болох нь гэж хичнээн түгшиж, болзошгүй аюулыг зайлуулахаар яахаа мэдэхгүй байснаа хоёр хөхөө гарган, Чингис хааныг зэмлэж байгаагаар хүний сэтгэлийн хөдөлгөөнийг маш хүчтэй илэрхийлжээ. Чингис хаан эхээ үзээд, маш их эмээж, Хасарыг сулласан боловч хожим нь далдуур хохироож, эд хөрөнгийг нь авсныг “эхдээ хэлэлгүй далдуур Хасарын зарим иргэнийг булаан авч, Хасарт нэг мянга дөрвөн зуун иргэнийг үлдээв” (Ц.Дамдинсүрэнгийн хөрвүүлэг. (1976) “Монголын нууц товчоо” Улаанбаатар. Зүйл 244. Тал 201) гэжээ. Энэ өгүүлбэрээр маш олон зүйлийг хэлж байна. Нэг талаас Чингис хааны хувьд эхээсээ өнгөн дээрээ айж, Хасарыг хөнөөгөөгүй боловч далдуур хохироосон зөрчилтэй байдлыг, нөгөө талаас эх нь хэрхэн шаналж зовсоор удалгүй нас барсан эмгэнэлтэй байдлыг харуулна.

Энд Өэлүн эхийн хэлсэн үгс нь түүний сэтгэлийн их хүчийг гаргаж чадсанаараа их гайхамшигтай. “Хавиргаа хадран хазагчид, хүйгээ хүчирхэн таслагчид...” гэж урьд цагт Бэгтэрийг алсныг дурьдаад,

“Тэмүүжин цээжиндээ эрдэмтэй,

Хасар хав хүчтэй тул

Хатгалдан зайлагсдыг

Харвах сумын хүчээр

Хамж авчирдаг билээ...”

гэх мэтээр Хасарын хүчийг магтан улс орноо нэгтгэхэд, Хасарын байгуулсан гавъяаг үнэлэхийн зэрэгцээ Чингис хааныг “Одоо дайсныг дарж төгсөв гэж Хасарыг үзэн ядаж байна уу?” (Ц.Дамдинсүрэнгийн хөрвүүлэг. (1976) “Монголын нууц товчоо” Улаанбаатар. Зүйл 244. Тал 200) гэж зэмлэж байна. Хаан ширээ булаалдан төрсөн ах дүү нар эвдэрч буй нь эхийн сэтгэлийг ихээр шаналгаж, алсдаа төр улс мөхөх аюултайг ухаарч, бачимдан буйг нүдэнд үзэгдэж, сэтгэлд ургатал зураглажээ.

Хоёр.

194, 195-р зүйлд Ван хаан дарагдмагц Найманы Таян хаан монголыг эзлэхээр “хоромсог саадгийг нь хураан аьчирья” (Ц.Дамдинсүрэнгийн хөрвүүлэг. (1976) “Монголын нууц товчоо” Улаанбаатар. Зүйл 189. Тал 138) гэж их үг

хэлсэн боловч эцэстээ ичгүүртэй ялагдаж буйг инээдэмтэй дүрсэлсэн. Таян хааны эх Гүрсэбү “ханхлах муу үнэртэй, хар муухай хувцастай” гэж монголчуудыг доромжилж байснаа олзлогдоно. Таян хаан монголчуудын хоромсгийг нь хураана гэж бардамнан байснаа монгол цэргийн бараанаас нь сүрдэн хулчийж байлдахаа болих гэсэн боловч Хүчүлүг хүүгийнхээ басаж хэлсэн үгэнд уурлаж, омог нь бадран тулалдах болно. Таян хааны хүчин их, аюултай байсан боловч түүний талд байлдах гэж байсан Жамух урван, монголчуудын байдлыг өсгөн ярихад, Таян хаан сүрдэж, улмаар ялагдахад хүрч байна.

Таян хаан Жамухаас “Тэр сүрэг хонинд орж, хотонд нь хүртэл хөөж яваа чоно мэт довтлогч ямар хүмүүс вэ?” гэвэл Жамух:

“Ширмэн төмөр малгайтай
Шивээ хурц хэлтэй
Ган төмөр зүрхтэй
Гадас цүүцэн хошуутай
Галзуу дөрвөн нохой
Түмэн амьтныг хядахаар
Төмөр гинжнээс мултарч
Шууд барьж идэхээр

Шунахай шүлсээ савируулж айсуй...”
(Ц.Дамдинсүрэнгийн хөрвүүлэг. (1976)
“Монголын нууц товчоо” Улаанбаатар. Зүйл 195. Тал 146) гэж Зэв, Хувилай, Зэлмэ, Сүбээдэй нарын тухай хэтрүүлэн хэлэхэд, Таян хаан “Тийм бол тэр муусайн амьтнаас хол байя” гээд хойш ухарч уул өөд өгсдөг. Энэ мэтээр таван удаа хаан асуухад, Жамух тэр бүрд сүртэй ярьсанд Таян хаан сүрдэж, Наху уул руу авир авирсаар оройд нь гарч буй нь монгол ардын аман зохиолд гардаг “давсалсаар давсалсаар” гэдэг зүйрлэлтэй дүйж, давталтын аргаар инээдэмтэй болгожээ. Ийнхүү “Монголын нууц товчоо”-нд инээдмийн зүйл байгаа нь “Хөнжилдөө орох завгүй хөнөөлдөн тулалдаж байсан” тэр хэцүү үед ард түмний ирээдүйдээ итгэх итгэл, амьдралын баяр баясгаланг харуулдаг.

Гурав.

Зохиолд драмын шинжтэй хэсэг олон. Жишээ нь: 166,167-р зүйлд Ван хаан хүү Сэнгүмийнхээ ятгалганд орж, Чингисийн эсрэг байлдах болдог. 164-д Ван хаан, Чингис хоёр эцэг хүү болж ёсолдог. Ван хаан Есүгэй баатартай анд байсан. Ийм олон шалтгаанаар Ван хаан Чингис хаантай байлдахад болохгүй байлаа. Эхлээд Жамух Сэнгүмийг ятган, Чингисийн эсрэг болгоно. Сэнгүм Тэмүжинг мэхэлж барих гэсэнд Тэмүжин мэхэнд нь ороогүй. Дараа нь байлдах гэж Ван хаанд хэлсэнд тэр зөвшөөрдөггүй. Эхлээд элч явуулж, дараа нь өөрийн биеэр ирсэн боловч

зөвшөөрсөнгүйд Сэнгүм гоморхон айлгана. Ван хаан “Тэмүжин хөвгүүнд тийм муу сэтгэж яаж болно? Бид Тэмүжин хөвүүнээр тулгуур болгож байгаа атал түүнд муу санавал тэнгэр биднийг таалахгүй” (Ц.Дамдинсүрэнгийн хөрвүүлэг. (1976) “Монголын нууц товчоо” Улаанбаатар. Зүйл 167. Тал 112) гэж буй нь түүний сэтгэлийн их тэмцлийг харуулдаг. Ийнхүү Чингисийн эсрэг байлдсанаар Хэрэйд улс мөхдөг.

Зохиолд Чингис Жамух хоёрын зөрчлийг их тодорхой харуулсан боловч Ван хаан Тоорил чухам ямар байр суурь баримталж байсныг төдий тодорхой өгүүлсэнгүй. Ямар боловч Есүгэй баатар Ван хаанд алдсан улсаа эргүүлж авахад нь тусалсан. Сүүлд Ван хаан Хятадын Гүр хаанаас зугтаж ирэхэд, Тэмүжин тэтгэж байсан гэх мэтээр хоорондоо их барилдлагатай байсан нь тэгж Ван хаан дайн үүсгэхдээ эргэлзэн буйгийн шалтгаан болдог. Гэвч Сэнгүмийн “Одоо чамайг амьд байхад тэр биднийг тоомсорлохгүй байна. Хэрэв хан эцэг чамайг цагаан идээнд цацаж, хар маханд хажвал Хурчахус-буйруг хан эцгийн зовж хураасан улс, зүдэж байгуулсан төрий нь бидэнд мэдүүлэхгүй болуузай” (Ц.Дамдинсүрэнгийн хөрвүүлэг. (1976) “Монголын нууц товчоо” Улаанбаатар. Зүйл 167. Тал 112) гэж буй нь ч бас оргүй үг биш байснаас Ван хаан эцэстээ дайтахыг зөвшөөрсөн бололтой.

Академич С.А.Козины хэлснээр “Бүх зохиолыг \Нууц товчоо\ нэвтрэн гарах үйл явдал нь хоёр их хүн Чингис, Жамух хоёрын эмгэнэлт тэмцэл” юм. Чингис Жамух хоёрын харьцаа нь зөрчил тэмцлээр дүүрэн. Арван нэгэн настайдаа анх анд болсон. Тэмүжин Бөртэ үжинг Мэргидээс булаан авахад, Жамух Тоорил хаантай нийлж тусалдаг. Ийнхүү андын холбоотой байсан учир тэр хоёр дайсан болох учиргүй байлаа. Гэвч Жамух Тэмүжинд атаархан өрсөлдсөөр дайсан болдог. Зохиолын явцад Жамухыг олонтаа урваж хөрвөж буй өөдгүй хүнээр дүрсэлсэн. Зүйл 200, 201-д Жамух баригдан ирснээр удаан уулзалдаагүй хуучин андууд уулзалдаж байна. Энд Жамухын хэлсэн үгнээс үзэхэд ухаалаг, зоригтой, алсын хараатай чухамхүү Чингис хаантай чадал ухаанаар дүйх өрсөлдөгч болох нь харагдана. Чингис хаан Жамухыг “өөр замаар явсан боловч өлзийт сайн нөхөр минь билээ...” гэж буй нь дипломат шинжтэйгээс гадна ер нь Жамухын эрдэм, ухаан, чадлыг нь үнэлж хүндэлснийг илэрхийлнэ. Тэгээд “Одоо бид хоёулаа ойртож нөхөрлөө” (Ц.Дамдинсүрэнгийн хөрвүүлэг. (1976) “Монголын нууц товчоо” Улаанбаатар. Зүйл 200. Тал 159) гэхэд Жамух:

Тэмүжин чи түмэн улсыг

Түвшин болгож
Харь улсыг хамтатган захирч
Хамгийг эзэлсэн хаан болоод ...байхад
Дэмий надаар юу хийх вэ?
Харанхуй шөнийн зүүд болж
Гэгээн өдрийн гэмтэн болж
Хаан андыг зовоох болно, би.
Энгэрийн чинь бөөс

Эгэмний чинь өргөс болох биз, би”
(Ц.Дамдинсүрэнгийн хөрвүүлэг. (1976)
“Монголын нууц товчоо” Улаанбаатар. Зүйл
201. Тал 161-162) гэж буй нь түүний хичнээн
ухаалаг, холын хараатай болохыг харуулдаг.
Ингээд дахин нөхөрлөхийг зөвшөөрөлгүй “Анд
чи соёрхож асгарах цусыг гаргалгүй алуулж
өршөө, намайг” (Ц.Дамдинсүрэнгийн хөрвүүлэг.
(1976) “Монголын нууц товчоо” Улаанбаатар.
Зүйл 201. Тал 163) хэмээн бардам эрэлхэгээр
үхлээ сонгож байгаа нь маш сайхан дүрслэгдсэн.
Ийнхүү Жамухыг дарагдсаны дараагаар 1206 онд
Чингис хаан өргөмжлөгдөж буй нь ч тохиолдлын
хэрэг биш Жамух бол Чингисийн гол өрсөлдөгч
байсныг баталж байна.

ДҮГНЭЛТ

Монголын хуучин уран зохиолын нэг онцлог
шинж нь драмын шинж юм. Энэ нь “Монголын
нууц товчоо”, “Чингисийн есөн өрлөгтэй өнчин
хүүгийн цэцэлсэн шастир”, “Эр хоёр загалын
тууж” зэрэг зохиолуудаас тодорхой харагддаг.
“Монголын нууц товчоо”-ны зарим өгүүллүүд
нь драмын шинжтэй. Тэмүжин багадаа Хасартай
нийлэн эцэг нэгтэй Бэгтэрийг харван алсан,
Хасарыг баривчлан байцааж буй зэрэг өгүүллүүд
нь маш гүнзгий эмгэнэлт зөрчлийг агуулжээ.
Хатуу ширүүн, хайр найргүй тэмцлийн дунд
нэгдсэн улсыг байгуулсан нь зохиолынхоо үйл
явдлуудын драматизмын үндэс болж байгаа юм.
Найманы Таян хааныг ялсан хэсгийн үйл
явдал инээдмийн шинжтэй нь ард түмний
өөдрөг тэмүүлэл, хамгийн хүнд хэцүү үед ч
сэтгэлээр уналгүй ирээдүйдээ итгэж явдгийн
баталгаа болж байна. Эцэг хүү болж ёсолсон
Ван хаан Чингис хоёр, анд бололцсон Чингис
Жамух нар хоорондоо дайсан болж байгаа
нь тухайн эрин үеийнхээ зөрчлийг тусгасан
явдал бөгөөд уг зохиолын гол зөрчил юм. Энэ
зөрчлийн тухай өөр өгүүлэлд бичих тул орхиж
шийдвэрлэх үеийг тусгасан хоёр өгүүллийг
авч үзлээ.

Үүнд Ван хаан яг Чингисийн эсрэг дайн үүсгэх
болсон хэсэг, Жамух дайтаж явсны эцэст баригдан

алагдаж буй хэсэг, Жамухын баригдсан хэсгийн
дүрслэл нь өнгөндөө зөрчилгүй мэт боловч цаанаа
маш ширүүн зөрчил агуулж байгаа юм. Энэ хоёр
их хүн санаа бодлоо ил хэлэхгүй дипломатаар
харьцаж буй боловч угтаа эвлэршгүй болох нь
илэрхий. Жамух хэдий ялагдсан боловч бардам,
эрэлхэг хэвээр үхлээ сонгож буй нь монгол баатар
эрийн шинжийг илэрхийлдэг. Энэ мэт драмын
шинжтэй жишээ олон боловч зарим нэгийг нь
дурдлаа.

1990-2016 он.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Козин, С. А. (1941). Сокровенное сказание
Монголов. Москва-Ленинград.
Дамдинсүрэн, Ц. хөрвүүлэг. (1976). Монголын
нууц товчоо. Улаанбаатар.
Гонгор, Д. (1970). Халх товчоон. Улаанбаатар
Түүхийн хүрээлэн. (1970). БНМАУ-ын түүх, 1-р
боть. Улаанбаатар.
ӨМӨЗО. (1988) “Монголын нууц товчоо” хурлын
материал. Хөх хот.

"Монголын нууц товчоо 750
жил." эмхэтгэл. 1990